

ХОЙД СОЛОНГОСЫН ТҮҮХЭН БА ӨНӨӨГИЙН БҮРХЭГ ЗАРИМ ХУУДСЫГ СӨХӨХҮЙ

*Д.Баярхүү**

Нэг. Их жанжин маршал Ким Чен Иррийн намтрын зарим хуудас

Хойд Солонгосын одоогийн удирдагчийн талаархи БНАСАУ-ын албан ёсны намтарыг орос, япон, америк, өмнөд солонгосын судлаачдын судалгаатай миний бие бяцхан харьцуулалт хийснээ дор буулгалаа. Энэ судалгаа бол ялимгүй бус, бүр алд дэлэм, итгэхэд бэрх байдлаар зөрж буйг дараахи хэсэгт буулгалаа.

Манай монголчуудад бол Ким Ир Сений ууган хүү, эцгээ залгамжлагч гэхээс цааш ойлголт төдийлөн байхгүй. Хойд Солонгосын тусгай албад япон иргэдийг хулгайлсан хэрэг дэгдсэн, “цөмийн” гэсэн тодотголтой хүчтэй тэсрэх бодит дэлбэлснээс үүдэн энэ улсын талаар гадаадын телевизүүд сенсаац дэгдээсэн нь манайхны нүд чихэнд эрхбиш хүрч, энэ улс, түүний удирдагч нь хэн нь хэн бэ гэдэг дээр гадаадын голдуу хэвлэлүүдийн мэдээлэл үе үе цухалзах болсон байна.

БНАСАУ-ын одоогийн удирдагч Ким Чен Иррийн албан ёсны тушаал нь Солонгосын Хөдөлмөрийн Намын Ерөнхий нарийн бичгийн дарга, БНАСАУ-ын Батлан хамгаалах хорооны дарга, БНАСАУ-ын маршал. БНАСАУ-ын албан ёсны намтар бичлэгээр бол энэ нөхөр 1942 оны 2 дугаар сарын 16-нд Пэктусан хэмээх уулын ойд партизаны отрядад хувьсгалчдын гэр бүлд төрсөн юм байна.¹ Харин оросын судлаачдынхаар бол (одоохондоо албан бус судалгаа гэж үзье) 1941 оны мөн сарын мөн тэр өдөр Хабаровскийн хязгаарт Юрий Ирсенович Ким нэрээр мэндэлсэн гэнэ.² Түүний эх Ким Жон Сук (“Солонгосын эх” хэмээн албан ёсоор нэрлэдэг) гэдэг нь их жолоодогч эцгийнх нь анхны хань бус, харин хоёр дахь нь, анхны эхнэр нь Ким Хё Сун нэртэй партизан эмэгтэй, япончуудад олзлогдоод гянданд хоригдож ахуйд нь Ким Чен Иррийн эхтэй гэрлэжээ.³ Москвад хэвлэгдсэн “Хойд Солонгосын албан бус түүх” номын хэсэгт яг ингэж өгүүлжээ. Бас нэг албан бус таамаг байна. Ким Чен Иррийн насыг хэргээр дарсан нь, эцэг нь 1912 онд, залгамжлагч хүү нь 1942 онд төрсөн болж, тэгш тоотой ойг нь нэг онд багтаан тэмдэглүүлэх зориудын тахин шүтлэгийн бодлогоос үүдэлтэй гэнэ.⁴

* Д.Баярхүү - УАБЗ-ийн дэргэдэх Стратегийн судалгааны хүрээлэнгийн судлаач, профессор

Энд бичсэн судалгааны өгүүлэл бол түүний төрд хашиж буй ажил албатай нь огт хамааралгүй бөгөөд Засгийн газрын байр суурийг илэрхийлээгүй гэдгийг уншигчид болгооно уу.

Ерөөсөө Ким Ир Сен гэдэг нь нууц нэр, тийм нууц нэртэй алагдсан олон партизаны удирдагчийн нэгийнх нь дүрээр оросууд өөрийн армийн ахмад нутгийн солонгос эрийг 1945 онд илгээсэн гэх таамгийг бүр 1990-ээд оны эхээр оросын судлаачид дэвшүүлж байв.⁵ Бас нэг таамаглал байна. Хожим партизаны алагдсан удирдагчийн дүрээр тодорсон хэмээн оросын энэ таамаглалөөс өмнөхөн, бидний мэдэх Ким Ир Сенийг эцэг эхээсээ Ким Сон Жу нэр заяагдсан, хөдөөгийн ламын хүү гэж 1988 онд Хавайн их сургуулийн профессор Со Дэ Сук нотолжээ.⁶ Зарим судалгаагаар бол, 1932 оноос энэ нэрийг зээлдэн хэрэглэсэн⁷ ба 1940-өөд онд жинхэнэ баатар тэр Ким Ир Сен нь алагдсан, эвсэл үхсэн бололтой.⁸

Ким Ир Сен нь удам судраараа хувьсгалч, Хойд Солонгосын уугуул иргэн гэх албан ёсны суртал нэвтрүүлэг байдаг ч баттай эх сурвалжаар бол өвөг эцгийнх нь булш Өмнөд Солонгосын Чонжу хотын орчим байна. Умард Чолла мужийн Чонжу-гаас XIX зууны 60-аад онд өвөг дээдэс нь хойшоо нүүдэллэсэн хэмээн өөрөө ч дуртгал номдоо бичиж үлдээжээ.⁹

Эцэг нь протестант шашинтан, христосын лам (миссионер) шашин номлож яваад Пхеньяны ойролцоо суурьшиж, бас нэг ламын охинтой гэрлэж хүүгээ төрүүлсэн гэх мэдээг оросын зарим эрдэмтэд “Хойд Солонгосын албан бус түүх” номдоо бичжээ.¹⁰

Сэдвийн гол баатар болох Ким Чен Ир-ийн тухайд бол одоо 66 настай (жинхэнэдээ 67-той), Япон ялагдмагц эцгээ даган Солонгост очоод 1950 оны Солонгосын дайн дэгдмэгц гурван жил Манжуурт тусгай хамгаалалтад байсан ба 1964 онд Ким Ир Сений нэрэмжит их сургуулийг улс төр-үзэл суртлын мэргэжлээр дүүргэж, Намын Төв Хорооны Үзэл суртлын хэлтэст зааварлагчаар ажлын гараагаа эхэлж, сэм сэмхэн дэвшсээр 1980 онд намын их хурлаар албан ёсоор ил гарч, Улс төрийн Товчооны гишүүн, Улс төрийн Товчооны Байнгын хорооны гишүүн, Төв Хорооны нарийн бичгийн дарга, Төв Хорооны Цэргийн зөвлөлийн гишүүн гэхчлэн нам-төрийн бүх оргил руу мацжээ.¹¹

Тэрээр 1980-аад оны турш нам-улсын гадаад бодлогыг хянаж, тусгай албадыг удирдаж байсан ба 1986 онд Рангунд өмнөд солонгосын боингийг дэлбэлсэн хэргийг гардан удирдаж байсан гэнэ. 1983 онд мөн Бирмд террорист халдлага үйлдэж, мөн л өмнөд солонгосын боингийг дэлбэлж, тэр үеэр 115 зорчигч алагдсаны дотор Өмнөд Солонгосын Ерөнхий сайд болон Засгийн газрын хэд хэдэн гишүүд нийт 17 албаны хүн байсан аж.¹²

XX зууны цэргийн гарамгай жанжин гэх энэ нөхөр үнэндээ иргэний хамгаалалтын нэгэн дадлагад хэд хоног болсноос цааш цэргийн “А” ч үгүй

хэрнээ 1991 онд БНАСАУ-ын зэвсэгт хүчний дээд ерөнхий командлагчаар томилогдож, 1992 онд ардын армийн маршал цол хүртжээ.¹³

1994 онд эцэг Ким Ир Сен нь нас нөгчиж, тэрээр залгамжилсан гэх намтар бий ч гэв гэнэт АНУ-тай харилцаагаа сайжруулахаар болж, Ерөнхийлөгч асан Ж.Картерийг айлчлуулж, Хойд Солонгосын гадаад бодлого 180 градусаар өөрчлөгдсөн ба түүнд өширхсөн цэргийнхэн нь Ким Чен Ир-тэй нийлээд өвгөн удирдагчийг цааш харуулсан гэх таамгийг ч гадаадын зарим судлаачид хийсэн байдаг.¹⁴

Солонгос заншлаар бол өвөг дээдсийнхээ гэрээсийг хөсөрдүүлэхгүй учиртай. Ким Ир Сен үхэхдээ надаас хойш Ерөнхийлөгч төрүүлж болохгүй, намын тушаалыг нь гурван жилийн дараа аваарай гэсэн шүү захиас үлдээгээд үхсэн гэх тайлбарыг Пхеньянаас хийдэг. Тэр дагуу 1997 онд Ким Чен Ир нь намын ерөнхий нарийн бичгийн дарга болж, Үндэсний батлан хамгаалах хороог толгойлжээ. Харин Ерөнхийлөгчийн албан тушаал нь эцэгт нь үүрд хадгалагдан үлджээ.¹⁵ Эрх зүйт төрийн онолоор бол БНАСАУ нь албан ёсоор амьд сэрүүн төрийн тэргүүнгүй гэсэн үг.

Солонгосын Хөдөлмөрийн Нам 1980 оноос хойш их хурлаа хийгээгүй, төр нь төрийн тэргүүнгүй, намын дарга нь цэргийн ангиудаас өөр хийх ажилгүй, цэргийнхэн нь нийгмээ төлөөлдөг, ард түмэн нь номхон хүлцэнгүй, улс төрийн хоригдлууд нь хэдэн зуу мянгад хүрсэн, цэрэгжиж шоронжсон тийм нэгэн улсыг Ким Чен Ир толгойлж байна.

Хувийн амьдрал нь тас нууц гэх боловч тансаг хоолонд маш дуртай, архи, авто машин, хүүхний хорхойтой, кино урлагийг их дээдэлдэг, тиймдээ ч 1978 онд өмнөд солонгосын кино найруулагч, жүжигчдийг хулгайлсан хэргийг удирдсан гэх нууц мэдээ буй.¹⁶ Эхнэр хүүхэд нь мөн л маш нууц сэдвийн нэг. Анхны авааль гэргий Ким Ён Сүктэйгээ 1970-аад оны эхээр суусан гэх мэдээ буй. Сон Хи Рим, Хон Ир Чон, Ко Ён Хи гэхчлэн олон бүсгүйн нэрс бий, чухам аль нь гэргий, алинтайгаа одоо сууж буй талаар ямар ч мэдээ алга.¹⁷ Ким Ён Сүк нь 1974 онд түүнд охин төрүүлж өгсөн боловч угсаа залгамжлал дээр охин хүүхдийг үзэж чаддаггүй дорно дахины заншлаар тэр хоёр хөндийрч, яваандаа салсан бололтой. Сон Хи Рим гэгч албан бус гэргий нь 1971 онд, албан ёсоор Ким Ён Сүктэй гэрлэхээс бүр өмнө Ким Чен Нам нэртэй нэгэн хөвгүүн төрүүлж өгсөн нь эдүгээ хүртэл хэл ам татлаад байж байна. Энэ залуу 2001 онд Доминикан улсын хуурамч паспортоор Японы хил нэвтэрч яваад саатуулагдаж бөөн сенсаац дэгдээсэн, 2004 онд энэ нөхрийг алахаар завдсаныг тусгай албад нь илрүүлсэн гэж мэдээлсэн. Албан бус бас нэг гэргий нь болох Ко Ён Хи гэгчээс угсаа залгамжлагч төрж байх магадлалтай хэмээн оросын судлаачид

таамагладаг. Эдүгээ 25 настай, цэл залуухан, Швейцарьт боловсорсон Ким Чен Чер нь эрх баригч намын Төв Хороонд суртал нэвтрүүлэг-ужуулгын аппаратыг удирдаж байна. Намын Төв Хорооны Үзэл суртлын хэлтэст эцэг нь зааварлагчаар ажлын гараагаа эхэлж байсантай адил түүх давтагдаж буй. Түүний дүү 20 настай Ким Чен Вун гэж бас нэг оюутан залуу эцгийнхээ залгамжлагчаар тодрох магадлалтай, эцэг нь 80 нас зооглох үед Ким Чен Вун тодрох болов уу, учир нь Ким Чен Ир өөрөө отгон хүүдээ их талтай гэнэ.¹⁸

Энд орхигдуулж болохгүй бас нэг мэдээлэл байна. Ким Чен Ирийн хувийн араншин нь нөлөөлсөн үү, Москва, Бээжингээс өөр явж үзсэн газар байхгүй, нисэх онгоцонд сууж үзээгүй, 2001, 2002 онд хуягласан галт тэргээрээ Орост айлчилж, Сибирийг туулсан энэ эрхэм гадаадад суугаа дипломатчидлаа маш хэрцгий ханддаг. Үр хүүхдээ Пхеньянд үлдээгээд өөрсдөө дипломат албаа хаш гэсэн хатуу захирамжаар хүүхдүүдээр нь эцэг эхийг нь барьцаалах мэргэн арга олжээ. СХН-ын Төв Хорооноос 2007 оны 2 дугаар сарын 14-нд гаргасан тусгай шийдвэрийн дагуу 5 наснаас дээш насны бүх хүүхдийг 30 хоногийн дотор Пхеньян руу буцаах тушаал буулгажээ.¹⁹ Учир нь гадаадад суугаа хойд солонгосын дипломатчид гэр бүлээрээ АНУ, БНСУ руу оргох явдал өмнө нь гарч байснаас тийм мэргэн арга сэджээ. Ийнхүү гадаадын 50²⁰ орчим улсаас дуудагдсан 3000 гаран гэмгүй нялх үрс хайрт удирдагчийнхаа барьцаанд орчихоод байна. Эцэг эх нь орговол тэд дуусах юм байна.

Эх эцгийн хайр, ханийн жаргал, үртэй байх жаргалыг үзэж мэдрээгүй энэ нөхөр ерөөсөө “хайр сэтгэл” гэдгийг ор тас үгүйсгэдэг мэдээ байна. Хойд Солонгост хайраараа гэрлэнэ гэдэг үнэхээр байшгүй үзэгдэл юм гэнэ. Гэрлэхийн тулд эхлээд ударник болох ёстой. Тэр нь аль ч салбарт тэргүүлж, гурван хувьсгалын (үзэл суртлын, соёлын, техникийн) хошууч байх ёстой. Тийм гавшгайчдыг нам-төр нь мэдэж заяаны ханийг нь зааж өгнө. Орон нутгийн намын байгууллагаас өөр нэгэн салбарын эсрэг хүйсийн нас ойролцоо гавшгайчийг зааж өгнө гэсэн үг. Ингээд олон зуун хосын сүржин хурим зохион байгуулсан жүжиг зохиогоод болдог бололтой.²¹ Харин дипломатчдын гэрлэлт арай ондоо. ГХЯ-ны гэр бүлгүй залуусын хувийн хэрэг Намын Төв Хорооны дарга нарын ширээн дээр байх ба тэд тэндээс сонголт хийж охидоо суулгах журамтай. Хэрэв биесээ таалахгүй бол эзгүй өрөөнд гурав хоног цоожлоод 4 дэхийн өглөө нээхэд нэг хөнжилд орсон байх тооцоотой ба энэ маягаар гэрлэх явдал түгээмэл хэмээн өмнөд рүү зугтаж гарсан нэгэн дипломатч ярьжээ. Хайр сэтгэлийг үздэггүй Юра Кимийн гэр бүлийн бодлого 22 сая хүн ард дээрээ буухад товчхондоо иймэрхүү.²²

Хоёр. Пхеньяны “1937 он”

Хэдийгээр өөрсдөө тэгж нэрлээгүй ч, БНАСАУ-ын түүхэн дэх “Цагаан толбо” хэмээн оросын судлаачид нэрлээд 1950-иад оны хэлмэгдүүлэлтийг нь нарийвчлан судалсаар байна. Энд “Хар”, “Цагаан” хоёр ондоо толбыг хугтаж болохгүй. Миний үзэхээр бол “Цагаан” гэдэг нь тийм түүхэн, бодит үйл явдал болсныг судлах, нотлох шатанд нэрлэсэн нэр, харин “Хар” гэхлээрээ нэгэнтээ нотлогдоод буруутгагдсан үйл явдлыг нэрлэсэн нэр болов уу. Тэгэхээр гарчигт өгүүлсэн үйл явдал (нэг ёсондоо төрийн террор) бол гадаадын судлаачдын судалж, нотлон гаргаж ирсэн тэдгээр баримтууд болно.

1945-1960 оныг бүхэлд нь Ким Ир Сений ганцаар захирах дарангуйллаа тогтоох хүртлэх улс төрийн хурц тэмцлийн түүхэн үе, харин 1953-1965 оныг Хойд Солонгосын түүхэн дэх “Цагаан толбо” гэж Солонгосын түүх судлаачид авч үзэж байна.

Хэдийгээр БНАСАУ нь коммунист тогтолцоотой коммунист улс гэж дэлхийд нэрлэгдэж ирсэн боловч жинхэнэ утгаараа коммунист нам, хөдөлгөөн энэ улсад төлөвшиж чадаагүйгээс тэрхүү “Цагаан толбо” нөхцөлдсөн гэж үзэх үндэстэй. Бидний мэдэх тэрхүү жолоодогч Ким Ир Сен бол коммунист нам, хөдөлгөөн, үзлээс дэндүү холуур явсан, итгэл үнэмшлээрээ бус хувийн хэтийн зорилгоо гүйцэлдүүлэх, Москвагийн стратегийг хэрэгжүүлэх зориудын гаднын бодлогын дүнд өөрөө хожим нь коммунист болсон гэх дүгнэлтэд зохиогч би хүрлээ. Коммунист дарангуйлагч нарт байдаг нийтлэг хувь заяа түүнийг тойроогүй, дайрсан, давтсан, эхлээд жинхэнэ коммунист намаа утсгадаг, коммунистуудаа алж цээрлүүлдэг, дараа нь өөрийн коммунист намаа бий болгож оройд нь залардаг, тийм л түүх Солонгосын хойгт давтагдсан юм байна.

Октябрийн хувьсгал дорно дахины боолчлогдсон улс түмнийг сэрээхэд Солонгосын хойг гадна нь үлдэж хоцорсон ба 1925 онд Коминтерний хүчтэй оролцоотойгоор Солонгосын Коммунист Намыг (СКН) нууцаар байгуулжээ. Уг нам дотроо хагарч бүтэлгүйтсэн, нийгмээсээ дэмжлэг хүлээгээгүйн гайгаар 1928 онд Коминтерний Гүйцэтгэх Хорооны тусгай шийдвэр гаргуулан байж татан буулджээ. Солонгосын коммунизмын түүх ийнхүү эхнээсээ л буруу замаар орсон тул хожмын түүхэн бүх завхралууд нөхцөлдсөн хэмээн америкийн хэсэг судлаач үзсэн байдаг.²³

1945 онд Зөвлөлтийн цэрэг Солонгосыг чөлөөлж байх үед ирээдүйн БНАСАУ-ын удирдлага 4 үндсэн бүлэглэлд (фракц) хуваагдаад байв. Тэдгээр нь “Орон нутгийн”, “Яньаний”, “Зөвлөлтийн”, “Партизаны” гэх. Японы эсрэг тэмцлийн жилүүдэд бие биеэ мэдэхгүй явсан, өөр хоорондоо хэлхээ холбоо байхгүй, 1945-1946 онд бие биеэ

мэдэлцсэн, зөвлөлтүүд хооронд нь танилцуулж, нэг тугийн дор нэгтгэсэн, харин ингэж танилцуулж байх үед Ким Ир Сений талынхан хамгийн цөөнхи нь, тэр үед дотоодын улс төрийн тэмцэл явагдсан бол шууд л ялагдахаар байсан бололтой.²⁴

Дээр нэр дурдагдсан 4 бүлэглэл гэж хэн байв, тэд яаж нэг болов оо? “Орон нутгийн” гэдэг нь Сөүлд төвтэй, Пак Хон Ён даргатай, 1925 онд СКН-ыг байгуулалцаж явсан хэсэг коминтернчидийн бүлэг байж, жинхэнэ коммунистууд нь энд бөөгнөрч байсан бололтой. “Яньваний” гэдэг нь 1920-иод онд Хятад руу дүрвэж гарсан, Шанхайд төвлөрч байснаа ХКН-ын бааз Яньан хот руу шилжсэн, Ким Ду Бон, Чве Чан Ик, Ким Му Жон гэх дарга нартай бүлэг байжээ. “Зөвлөлтийн” гэдэг нь аль XIX зуун, XX зууны эхээр Орос руу дүрвэсэн, оросжсон солонгос цагаачдын удам, Москвагаас зориудын буй болгосон, хэрдээ боловсролтой хэдэн зуун солонгосчуудаас бүрдсэн бүлэг байв. “Партизаны” гэдэг нь Манжуурт бүгж асан, тоогоор цөөн партизаны отрядын дайчид, эдэн дундаас Ким Ир Сен өөрөө тодорчээ.

Чөлөөлөгдсөн Пхеньянд коммунист намыг Москвагаас томилогдсон коминтернч Ким Ён Бом эхэндээ толгойлж байв. Сөүл дэх Төв Хорооноосоо захирагддаг СКН-ын Умард Товчоог Зөвлөлтийн цэргийнхний онцгой дэмжлэгийг хүлээсэн Ким Ир Сен 1946 оны хавар гэхэд салгаж, намыг хоёр хуваажээ. Өөрийн толгойлсон хэсэгтээ “Партизаны”, “Зөвлөлтийн” фракцуудыг оруулж, нөгөө хоёрыг нь гадна үлдээжээ. Хуваагдсан СКН-ыг нийлүүлэх тушаал Сталинаас 1946 оны зун ирж эргэж нийлсэн ба өнөөгийн Солонгосын Хөдөлмөрийн Нам (СХН) тэр үед мэндэлсэн гэж үздэг. Шинэ намын даргаар нэр хүнд, туршлага, боловсролоороо хэт давуу профессор Ким Ду Бон тавигдаж, зөвлөлтүүд түүний сүүдэрт өөрийн армийн офицер Ким Ир Сенийг эрх мэдэлтэй нь авч үлджээ. Гэтэл энэ үетэй зэрэгцэн Сөүлд нууцаар бас нэг СХН (Ө) байгуулагдан, даргаар нь коминтернч Пак Хон Ён гарч ирсэн ба тэд 1946-1947 онд Пхеньянд зугтан ирж, Хойд Солонгост зэрэгцсэн хоёр ч СХН ажиллаж байсан сонин түүх буй.²⁵

БНАСАУ байгуулагдсаны дараа 4 фракц бүхий хоёр тусдаа СХН ажилласаар байсан ба 1949 оны 6 дугаар сар гэхэд зөвлөлтүүд хуваагдмал хоёр намыг нэгтгэж, даргаар нь Ким Ир Сенийг²⁶ тавьж, орлогчоор нь Пак Хон Ён, зөвлөлтийн оросжсон солонгос Алексей Иванович Хегай (Хө Ги И) нарыг томилжээ. Ийнхүү дотоод улс төрийн тэмцлийн нэг үе шувтарч, зөвлөлтийн улаан армийн ахмад, Пхеньяны орос комендатын туслах Ким Ир Сен Хойд Солонгосын эрх баригч коммунист намын хууль ёсны дарга болж чадлаа. Энэ томилгоонд зөвлөлтүүд маш хүчтэй оролцож, өөрийн төлөөний хүнээ зүтгүүлж,

“Зөвлөлтийн” бүлэглэл ч онцгой үүрэг гүйцэтгэсэн байна. Харин тэмцлийн явцад Ким Ир Сен нь фракцаасаа урваагүй, “Партизаны” нөхдөө дээш татсаар чангаасаар иржээ. Үүний тодорхой жишээ нь Москвагийн хэт оролцоог хязгаарлах эхний оролдлогууд нь байв.

Хэдийгээр Солонгосын дайн ид өрнөж, үхэх сэхэхээ үзэж байсан ч “Зөвлөлтийн” бүлэглэлийн биет удирдагч, Москвагийн хянагч А.И.Хегайг 1951 оны намар намын дэд даргаасаа авч хаян, улмаар 1953 оны зун гэнэт үхүүлсэн явдал байв. Үүнтэй зэрэгцүүлэн хятадын тал баригч яньанийханд давхар цохилт өгчээ. Хэдийгээр хятадын сайн дурынхан солонгосчуудыг үхлээс аварч, нам, төр, Төв Хороо нь Хятадын хил дотор бүгж байсан ч 1950 оны 12 дугаар сарын бүгд хурлаараа яньанийхныг бут ниргээд, заримыг нь Хятад руу хөөсөн буюу үхүүлсэн байна. Му Жон, Пак Ир У гэхчлэн Маогийн ивээлд багтсан хүмүүсийг зориглон авч хаяжээ. 1952 оноос “Орон нутгийн” фракц руу дайралтын галаа чиглүүлжээ. Чингэхдээ “Зөвлөлтийн” ба “Орон нутгийн” бүлэглэлүүдийг хооронд нь үзэлцүүлж, хамтад нь фракционизм гэгчээр ялласан байна.

Солонгосын дайны гал зогссон 1953 оны зун Пхеньянд шүүн таслах томхон хурал зохион байгуулав. СХН-ын Төв Хорооны нарийн бичгийн дарга Ли Сын Ёп тэргүүтэй коммунист хөдөлгөөний 12 зүтгэлтэнд төрийн эргэлт хийхээр хуйвалдсан, Өмнөд Солонгос дахь коммунист хөдөлгөөнийг нураасан, японы эзэгнэлийн үед японы цагдаагийн мэдээлэгч байсан, АНУ-ын төлөө тагнуул хийсэн гэх 4 зүйл ангиар яллаж, 10-т цаазаар авах, хоёрт нь гянданд удаан хугацаагаар хорих ялаар цээрлүүлжээ.²⁷ Энэ үеэр Пак Хон Ёныг баривчлан гэрийн хорионд хийгээд байсан ба 1955 оны 12 дугаар сард шүүх хурлыг зохион байгуулж, бүр 1939 оноос америкийн тагнуул байсан, америкийн тусгай албаны даалгавараар коммунист хөдөлгөөнийг нураасан хэмээн яллаж, цаазаар аваачих ял тохож, 1956 оны намар буудан хороожээ.

Ли Сын Ёп, Пак Хон Ён гэсэн хоёр том өрсөлдөгчөөсөө Ким Ир Сен салж авмагц “Орон нутгийн” гэх фракц хамт алга болов. Залгаад “Зөвлөлтийн”, “Яньаний” фракцууд руу илээр довтоллоо. Улсын төлөвлөгөөний хороог толгойлж байсан зөвлөлтийн солонгос Пак Чхан Окийг авч хаян, “Яньаний” фракцын Юн Го Хым (Худалдааны сайд) тэргүүтэй хэсэг нөхдийг алахын даваан дээр Хятад руу зугтаалгав. Ийнхүү Пхеньянд үл ойлгогдох, тогтворгүй байдалд хүргэж мэдэх тэмцэл өрнөж байх үест Бээжинд ХКН-ын VIII их хурал хуралдаж таарсан бөгөөд ЗХУКН, ХКН-ын хамтарсан төлөөлөгчдийг А.И.Микоян, Пэн Дэхуй нараар ахлуулан Бээжингээс Пхеньян руу илгээхэд арга буюу хүрсэн байна.²⁸ Ким Ир Сен нь хоёр ахынхаа

тулгалт, шаардлагыг хүлээн авч Хятад руу зугтагсад эргэж очин хуучин албан тушаалдаа тавигджээ. Гэвч тэмцэл далд хэлбэрээр дахин үргэлжлэв. 1956 оны сүүлчээс тус орон даяар “Үзэл суртлын шалгалт” гэх кампани өрнөж, яньаньчууд хамгийн түрүүн өртлөө. Нэг ёсондоо террор гэж нэрлэмээр энэ кампанит ажил хоёр жил өрнөхдөө үй олноор нь баривчлах, эрүү шүүлт тулгах, олны нүдэн дээр илээр буудан хороох хэлбэрээр явагдсан ба яньанийхан бүрэн утсгагдаж, тэдний толгойлогч, СХН-ын анхны дарга Ким Ду Бон цаазаар авахуулжээ. Ингээд 1958 оноос сүүлчийн фракц болох “Зөвлөлтийнхөн” рүү бууны ам чиглэжээ. 1958 оны намар Москвагийн тавиул – флотын штабын дарга адмирал Ким Чхиль Сон, Ерөнхий сайдын орлогч Пак И Ван нарыг баривчлан, 1959 оноос хавтгайруулсан баривчилгаа явуулж, орос хэлтэй солонгос сэхээтнүүдийг бүгдийг хомроглов.²⁹ Зарим нь тухайлбал Пан Хак Сё, Нам Ир, Пак Ден Ай, Пак Жон Э нар Ким Ир Сений дуулгавартай гар хөл болж, хэлмэгдүүлэлтэд оролцжээ. “Зөвлөлтийн” фракц 1960 он гэхэд үндсэндээ утсгагдаж, азаар амь үлдсэн тухайлбал СХН-ын зүтгэлтэн Сон Вон Сик, Ким Ир Сений их сургуулийн ректор Ю Сон Хун, Москвад сууж асан Элчин сайд яньаньч Ли Сан Жо нарын хэсэг нөхөд Москва руу амь тавин зугтжээ.

Цэвэрлэгээ 1960-1970-аад онд сааралгүй үргэлжилсэн ба цөлөх, цөллөгт үхүүлэх, авто ослоор үхүүлэх хэлбэрээр явагдаж байв. Жолоодогчид үнэнчээ харуулсан оросжсон солонгос Нам Ир, Пак Жон Э нар хэдийгээр нам-төрийн өндөрдөгт гарч, Улс төрийн Товчоо, түүний Байнгын Хорооны гишүүд байсан боловч 1968 онд Пак Жон Э гэнэт алга болсноо хоёр жилийн дараа тушаал буурч ил үзэгдсэн, Нам Ир нь 1976 онд авто ослоор үхсэн, мөн яньаньч Ким Чхан Ман (жолоодогчийн үзэл сурталч) цөллөгт үхсэн гэхчлэн нэрсийг жагсааж болох байна.³⁰

Дүгнэж үзвэл, Ким Ир Сен нь өөрийн дэглэмээ бэхжүүлэх, өөрийгөө тахин шүтүүлэх тэмцэлдээ 15 жилийг зарцуулж, үйл олныг хамарсан террор үйлдсэн ба эхний шатанд (1945-1949 он) зөвлөлтийнхний хүчээр улс төрд гарч ирсэн, тэдний дуулгавартай зарц маягаар ажилласан, ингэснээр СХН-ын удирдлагыг гартаа оруулж чадсан байна. Хоёр дахь шатанд (1950-1961 он) Москвагийн бодлогоос зай барьж, Зөвлөлтийн ашиг сонирхлыг Солонгосоос аажмаар шахсан байна. Ингэхдээ 1950-1953 оны дайнтай давхцуулан зөвлөлтийн, яньанийн бүлэглэлийн хамгийн аюултай өрсөлдөгчдөө хөөн зайлуулаад, орон нутгийн фракц руу довтлох бэлтгэлийг хангажээ. 1953-1955 онд орон нутгийнхныг бут ниргэж, ихэнхи удирдагчдыг нь алсан буюу гянданд хорьсон байна.

Мөн энэ 15 жилд Солонгос дахь коммунист бус бүх хүчнийг устгаж дууссан ба 1960-аад он гэхэд ганц ч өрсөлдөгчгүй, хэмжээгүй эрхт

дарангуйлагч болж чаджээ. 1957 онд СХН-ын Төв Хорооны Улс төрийн Товчооны Байнгын Хорооноос “Хувьсгалын эсэргүү элементүүдтэй хийх тэмцлийг бүх ард түмний, бүх намын хөдөлгөөн болгож өөрчлөх тухай” тогтоол баталж,³¹ 1959 онд жолоодогчийн төрсөн дүү Ким Ён Жу тэргүүтэй тусгай албыг НТХ-ныхоо дэргэд байгуулснаар Хойд Солонгосын бүх хүн амыг хамарсан цэвэрлэгээ, шалгалт, хяналтын сүлжээг буй болгож, тоталитари сталинч дэглэмээ институтчилэв. Эл тогтоолын дагуу 22 сая хүн амаа гурван бүлэгт хуваав. “Дайсагнагч хүчин”, “Төвийг сахигч”, “Найрсаг хүчин” гэх энэ ангилалаар бол эхний хүчнийг устгах ёстой ба энэ бүлэгт 1) Өмнөд Солонгос руу дүрвэсэн хүмүүсийн гэр бүл, 2) Газрын эзэн, худалдаачин, лам явагсад, тэдний гэр бүл, 3) Дайны үед өмнөд солонгосын цэрэгт олзлогдогсад, тэдний гэр бүл, 4) Японы эзэгнэлийн жилүүдийн төрийн албан хаагчид, тэдний гэр бүл, 5) Шоронгийн ялтан, тэдний гэр бүл, 6) СХН дахь фракцынхан, тэдний гэр бүл гэж 6 ангилан цэвэрлэгээний шүүлтүүрээр оруулав. Харин найрсаг хүчин гэдгээ 1) Амь эрсэдсэн хувьсгалчдын гэр бүл, 2) Амь эрсэдсэн цэргийнхний гэр бүл, 3) Кадр ажилтан, тэдний гэр бүл хэмээн гурав ангилан жолоодогчийн халамж үзүүлэх жишээтэй.³²

СХН-ын Төв Хорооны дээрхи лут тогтоолыг дэмжиж Засгийн газраас №149 тогтоол баталж, дайсагнагч хүчнийг хэрхэх тухай нарийвчлан зааж өгсөн ба 1961 он гэхэд тэднийг нийгмээсээ шахаж дуусчээ. 1964 онд СХН-ын Төв Хорооны бүгд хурлаас “Хүн амын янз бүрийн давхарга, бүлгүүдтэй зохиох ажлыг цаашид эрчимжүүлэх тухай” тогтоол баталж, нөгөөх “Дайсагнагч хүчин”, “Төвийг сахигч”, “Найрсаг хүчин” гэх гурван бүлгээ задалж 51 бүлэг болгожээ. Найрсаг гэдэг нь “Үндсэн” гэсэн нэртэй дотроо 12, төвийг сахигч гэдэг нь “Тээнэгэлзэгчид” гэсэн нэртэй дотроо 9, дайсагнагч нь 30 бүлэг болж задраад³³ энэ шүүлтүүрийн цаана үлдэх нэг ч иргэн БНАСАУ-д жолоодогч, түүний залгамжлагчаас өөр үлдээгүй байна.

“Үндсэн” – 12

- 1) Ажилчин, түүний гэр бүл
- 2) Барлаг тариачин асан, түүний гэр бүл
- 3) Ядуу тариачин асан, түүний гэр бүл
- 4) Төрийн албан хаагч
- 5) СХН-ын гишүүн
- 6) Хувьсгалт тэмцлийн тулалдаанд ам эрсэдсэн хувьсгалчдын гэр бүл
- 7) Хувьсгал, үндэсний эрх чөлөөний хөдөлгөөнд ам эрсэдсэн хувьсгалчдын гэр бүл

8) Хувьсгалт сэхээтнүүд (зөвхөн чөлөөлөгдсөнөөс хойш боловсрол эзэмшсэн байх ёстой)

9) Дайны үед алагдсан энгийн иргэдийн гэр бүл

10) Солонгосын эх орны дайнд алагдсан дайчдын гэр бүл

11) Цэргийн албан хаагчдын гэр бүл

12) Дайны баатрууд

“Тээнэгэлзэгчид” – 9

13) Жижиг худалдаачин асан

14) Дунд худалдаачин асан

15) Жижиг гар урчууд асан

16) Жижиг үйлдвэрийн эзэн асан

17) Үйлчилгээний салбарт жижиг үйлдвэрийн эзэн асан

18) Үйлчилгээний салбарт дунд үйлдвэрийн эзэн асан

19) Солонгосын дайны үед Өмнөд рүү гарсан иргэдийн гэр бүл, гэхдээ Хойд Солонгосын улс төр, төрийн байгууллын эсрэг ямар нэг хэрэг хийгээгүй байх ёстой

20) Дунд тариачин асан

21) Өмнөд Солонгосоос ирээд фракцын тэмцэлд оролцож явсан этгээд

“Дайсагнагч” – 30

22) Нийгмийн гарал нь сэжиг бүхий ажилчин

23) Нударган баян асан

24) Жижиг дунд капиталын төлөөлөл – худалдаачин асан

25) 1946 онд газрын реформ хийх хүртэл 0.99 га талбай эзэмшиж байсан нударган

26) Япон, Америкийн төлөө үйл ажиллагаа явуулж байсан этгээд

27) Японы эзэгнэлийн үед Японы засаг захиргаанд ажиллаж асан харгис түшмэл

28) Нийгмийн гарал нь сайн, гэвч гэмт хэрэг үйлдсэн, эсвэл Өмнөд рүү зугтсан этгээд

29) Дайны үед Өмнөд рүү дүрвэсэн, нийгмийн гарал нь сэжиг бүхий этгээд

30) 1950-иад онд Хятадаас ирсэн хятадын солонгос

31) 1960-аад онд Японоос ирсэн японы солонгос

32) Өмнөдөөс дүрвэн ирэгсэд, гэвч 21 дүгээр ангилалд багтах ёсгүй

33) Чөлөөлөгдөхөөс өмнө боловсрол эзэмшсэн сэхээтнүүд

- 34) Протестант шашинтан, шүтлэгтэн
- 35) Буддист шашинтан, шүтлэгтэн
- 36) Католик шашинтан, шүтлэгтэн
- 37) Орон нутгийн күнзийн шашинтан, шүтлэгтэн
- 38) СХН-аас хөөгдсөн этгээд
- 39) Албан тушаалаасаа хөөгдсөн кадр ажилтан
- 40) Дайны үед нутагтаа Америк, Өмнөд Солонгосын цэрэг, цагдаа, төрийн аппаратад ажиллаж асан
- 41) Шоронгийн ялтан, түүний гэр бүл
- 42) Тагнуулын байгууллагатай холбоотой этгээд, түүний гэр бүл
- 43) Намын эсрэг, хувьсгалын эсэргүү, фракцын элемент
- 44) Улс төрийн хэрэгт шийтгэгсдийн гэг бүл
- 45) Улс төрийн хэрэгт шийтгэгдээд хугацаанаас өмнө суллагсад
- 46) Хулиган танхай этгээд
- 47) Сэжиг бүхий эмс- бөө удган явсан, хормойн донтон, биеэ үнэлэгч
- 48) Хулгай, шамшигдуулалт, эдийн засгийн бусад гэмт хэрэгт шийтгэгдэж байгсад
- 49) Тэнгэрийн замын залуу нөхөд намын гишүүн асан
- 50) Ардчилсан Намын гишүүн асан
- 51) 1946 онд хөрөнгөө хураалгасан хөрөнгөтнүүд ажээ.³⁴

Гурав. Империализмыг хиар цохих төлөвлөгөө

Өгүүллийн гурав, дөрөвдүгээр бүлэг өмнөх хоёр бүлгээсээ шал өмнөө сэдвийг хөндөж, орчин үе рүү хандана. Хойд Солонгосын өнөөгийн бодит байдал, ялангуяа дэглэм нурах, гаднаас нураах боломжит хувилбар, түүний эсрэг хориглолт, тус орны милитаричлалыг зарим талаас нь энд хөндөв. Зохиогчийн хувийн судалгаа, дүгнэлт гэхээсээ гадаадын цэргийн шинжээчид, гадаадын хэвлэлүүдийн мэдээлэл дор голлосон болно.

Зангидсан нударгаараа конгрессын байшинг няц цохиж буй солонгос цэргийн плакат, мянган америк чоныг улаан гараараа тасдаж алах тухай эвлэлийн гишүүний тангараг, байн байн зарладаг байлдааны цагийн байдал, энгэр дүүрэн хуванцар одон гялалзуулах генерал адмиралуудын сүрт жагсаал, газар тэнгэр доргитол уухайлах олон түмний түрлэг, энэ бүхэн өнөөгийн Хойд Солонгосын бодит дүр зураг,

нийгмийнх нь төрх болчихоод байгаа. Энэ тухайд тус улсын хэвлэлүүд, интернэтээс хангалттай мэдээлэл авч болно.

Хүүхдийн цэцэрлэгт америк цэргийн чүүчил жадалж сургуулиласан солонгос багачуул пионер болж улаан бүч зүүмэгцээ 100 америк чоныг, эвлэлд элсвэл 1000-ыг, намд элсэхээрээ 10 000 америк чоныг ална хэмээн андгай тангараг өргөж хүн төрөхөө олдог дүр зураг харагдаж байна. Плакатнуудаас харвал Хойд Солонгосын дэргэд АНУ ердөө л цаасан бар юмсанж. Япон, Өмнөд Солонгосыг бол арчиж хаяна, хохь нь шүү гэсэн заналхийлэл захын солонгос генералын амны уншлага болсон бололтой хэмээн оросын судлаач, сэтгүүлчид гайхшран бичиж болжээ.³⁵

2004 оны намар тэр үеийн НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга К.Аннанд хаягласан нэгэн захидал Пхеньянаас очиж, дэлхийн хамтын нийгэмлэгийг баахан сандраажээ. Умард, өмнөдийг заагласан цэрэггүй бүсэд БНАСАУ-ыг төлөөлдөг хурандаа генерал Ри Чан Бок гэгчийн гарын үсэг бүхий тэр албан захидалд: Төсөөлснөөс чинь шал өөрөөр, хүний амь аймшигтайгаар үрэгдэх, урьд хожид үзэгдээгүй, хамгийн хэрцгий дайн хийх болно шүү, Солонгосын хойгт АНУ цэргээ байлгаж байгаа тохиолдолд дайн зайлшгүй шүү хэмээн заналхийлээд, америкийн цэргийг гаргаж, НҮБ-ын цэргийн командлалыг татан буулгахыг шаарджээ.³⁶

БНАСАУ-ын Гадаад хэргийн дэд сайд Пак Дон Чун гэгчээс хэдэн жилийн өмнө манай төлөөлөгчдөд ярьсан ярианы тэмдэглэл дотор дараахи үгс байна. “Манай төрийн тогтолцоог нурааж, манай улсыг устгах бодлого нь эцсийн эцэстээ дайнд хүргэнэ. Үүнд бид хатуу цохилт өгөх болно. Манай их жанжин Ким Чен Ир цэргийн ангиудаараа байнга явж, армия бэхжүүлэхэд их анхаарч байна. Манай армийн сүр хүчнээс Өмнөд Солонгос, Япон, АНУ үхтлээ айж байгаа. Бид цохилтын төвийг Японд чиглүүлэх бөгөөд түүнийг нэг мөр устгах чадал ч бидэнд байна” гэжээ.³⁷ Өдөр бүр шахуу Пхеньянаас цууриатдаг дайнч уриа, заналхийллүүдийн хоёрхоныг жишээ болгон дурдаж байна.

Дэлхийн коммунист систем нурж, аюулгүй байдлын гол баталгаа СССР тарж, эдийн засгийн гүн хямрал Хойд Солонгосыг гэнэт нэрвэж, өлсгөлөнгөөр 2 сая хүнээ алдсан ба цэрэгжсэн дэглэмээ торгоох шинэ тактик Ким Чен Ир сонгожээ. Пуужингийн технологи бүтээж, үйлдвэрлэж экспортлоход Хойд Солонгосын дотоодын таагүй байдал, эдийн засгийн уналт, ард түмний ядуурал нь огтхон ч садаа болоогүй аж. Сөүлийн Олон улсын харилцааны судалгааны хүрээлэнгийн тооцоолсноор бол БНАСАУ пуужин хөөргөх иж бүрэн цогцолбор баазаа зүүн хэсэгтээ байгуулсан ба 250 пуужин үйлдвэрлэн харвахад бэлэн болгожээ. Алсын тусгалтай пуужингууд нь АНУ, Япон хүртлэх зайд нислэг үйлдэх хүчин чадалтай, одоо Өмнөд Солонгос руу онилсон

ойрын тусгалтай хөдөлгөөнт пуужингийн командын төвөө байгуулж байна.³⁸ Хойд Солонгосын гадаад бодлого, батлан хамгаалалт нь зэрэгцээд хэрэгжиж байдал нь энэ аж. Дотооддоо нүүрлэсэн гай түйтгэрээ “АНУ-ын империализм” гэгчээр олон жил тайлбарласан, тэр тайлбараар бол айлгаж мөнгө олох, айлгаж тусламж хүртэх нь бас нэгэн шинэ тактик нь бололтой. 2007 оны намар хоёр Солонгосын хоорондын галт тэрэгний аяллыг эхлүүлсэн нэрээр төмөр замаа сэргээсэн маягтай шоу үзүүлэхдээ Өмнөд Солонгосоосоо 80 сая ам.доллар гаргуулж бараг дээрэмдэж шахуу авав.³⁹

Цайз бэхлэлт, окоп, нуувч – энэ улс милитарчилалын сонгодог жишээ, бүр оргил нь гэмээр тоо баримт зөндөө. Цэргийн зардал нь 1.9 тэрбум ам.доллар, ДНБ-ийхээ 14 хувиас давна, 24.5 сая хүн амд нь ногдуулбал дэлхий дэх дайтаж байгаа улсуудынхаас давж гарна. Саяас дээш тооны цэрэгтэй улс дэлхийд 5 бий, Хятад хамгийн их нь 2.2 сая, АНУ удаалж 1.4 сая, Энэтхэг 1.3 сая, Орос 1.2 сая, 5-рт Хойд Солонгос 1.1 сая цэрэгтэй. Цэргийг нь энгийн иргэний тоотой харьцуулбал Энэтхэгт 1 цэрэгт 788 иргэн, Хятадад 1:577, АНУ-д 1:202, Орос 1:116, харин Хойд Солонгост 1:22 гэсэн харьцаа гарч, дэлхийн хамгийн их цэрэгжсэн дайнч улс гэдэг ангилалд ордог байна. Энд зөвхөн хуаранд алба хааж буй хугацаат цэргийг нэрлэж буй, харин цэрэгжсэн хүчний 200 мянга, дайчилгааны нөөцөнд буй 4.7 саяыг оруулж тооцоогүй. Солонгосын ардын армийн байлдагч түрүүч нарын алба хаах хугацаа төрөл мэргэжлээсээ шалтгаалаад 5-10 жил, халагдлаа ч нөөцөнд байнгын сургуулилалттай, зэвсэг нь хэзээд бэлэн. Их жанжин Ким Чен Ир дайчилгаа зарлалаа гэхэд бид 6 сая гаруй зэвсэглэсэн хүн жагсааж чадна гэж хойдуул байнга сайрхдагийг бас энд дурдахад илүүдэхгүй.⁴⁰

Орчин цагт тус бүс нутагт, тэр дундаа Зүүн Азийн эдийн засгийн хамтын нийгэмлэг төлөвших шатандаа орж, БНАСАУ-ыг тойрсон эдийн засгийн хурдацтай өсөлт, интеграц, олон талт хамтын ажиллагаа ид өрнөж буй үед энэ их цэрэг, зэвсэг, милитарист хийрхэл, цэргийн зардал хэнд хэрэгтэйг төсөөлөх ойлгох хүн байхгүй болов уу.

Хэрэв нэг бүрчлэн цааш тоочвол: Хойд Солонгосын байнгын арми нь явган цэргийн 63 дивиз, танкийн 30 дивиз, их бууны 16 дивиз, 64 тусгай бригадтай, нөөц дивиз нь 40, 18 тусгай бригад. Зэвсэглэлд нь 3500 танк, 2500 хуягт, 10 400 их буу, тактикийн ба оператив-тактикийн пуужин харвах 54 төхөөрөмж, 2500 капош, 11 000 зенит, агаарын хүчний 6 дивиз, үүнд бөмбөгдөгч онгоцны 2, сөнөөгч онгоцны 4 дивизэд нь 621 байлдааны нисэх онгоц, 24 вертолет, тэнгисийн цэрэгт нь 84 шумбагч хөлөг, 250 катер, 6 том байлдааны хөлөг гэхчлэн жагсааж болно. Хөнгөн зэвсэг, миномет, гранат шидэгч, галаар шүршигч, сум, гар бөмбөг, хутга жад гэвэл хэмжээ хязгааргүй их тоо гарна.⁴¹

Тооны цаана чанар, тэр дундаа XXI зууны орчин цагийн мэдээлэл-технологийн эриний дайны царыг даах чадвар гээд яривал Хойд Солонгос цэрэгжсэн плакатуудтай харьцуулахад үнэхээр эмгэнэлт дүр зураг буухаар бас нэгэн баримтыг сөхье. Солонгосын ардын армийн дээрхи олон дивизийн ихэнхи нь дэлхийн II дайны үеийн, өөрөөр хэлбэл Зөвлөлтийн улаан армиас аль эрт халагдсан хасагдсан зэвсэг, байлдааны техникээр дайтахаар байна. “Нохойтой 4 танкчин” кинонд гардаг, манай Зайсангийн аманд хөшөө болчихоод буй “Т-34” танкийг бид олон мянгаар нь тэнд л үзэж болох юм байна. Миг-17, Миг-19 нисэх онгоцууд Орост музейд байдаг бол тэнд байлдааны нислэгт, Сүүл, Токиог бөмбөгдөхөд бэлэн байлгаж буй. Гэхдээ ихэнхи нь шатахуунгүй. Флотын хөлөг онгоцууд ч мөн адил. Дайчилгааны нөөцөнд буй 4.7 сая цэргийн бэлтгэл гэвэл бүр дор, тээврийн хэрэгсэл, хүнд зэвсэг гэхээр юмгүй, орос хятадын үйлдвэрийн буудлагын хөнгөн зэвсэг, гар гранат, хөнгөн их буу, гэхдээ мөн л 1940, 1950-иад оных.⁴²

Харин авах юм нэг бий нь Солонгосын ардын армийн тагнуул-хорлон сүйтгэх тусгай хүч нь 100 мянгаас давж, энэ үзүүлэлтээр АНУ-ын тусгай хүчнээс гурав дахин их байгаа нэгэн баримт буй. Ер нь хорлон сүйтгэх-партизаны дайнд (нэг үгээр террорист халдлага) маш их бэлтгэсэн нь чухам Өмнөд Солонгос, Япон, АНУ-ыг айлгах давуу тал нь гэнэ.⁴³

Цэрэг эрсийнх нь эр зориг, Их жанжиндаа хязгааргүй үнэнч шүтлэг бишрэл, Матросов маягаар камиказейн үхлээр үхэх хүслэн, суртал нэвтрүүлгийн аман заналхийллийг нь эс тооцвоос хүсээд буй тэр их дайндаа Их жанжин маршал Юра Ким Та бэлэн үү гэж ам асуумаар юм шиг.

Дөрөв. Болзошгүй дайны зарим хувилбар

Хойд Солонгосын коммунист удирдагч Ким Чен Ир огцорч, сайн дураараа Солонгосоос гарсан тохиолдолд сталинч коммунизмын хамгийн сүүлчийн цайз – энэ орны эсрэг Иракийн дайн шиг сунжирсан мөргөлдөөн дэгдэхгүй байж болох тухай АНУ-ын БХЯ, ТТГ тооцоолж буй талаар CNN, BBC зэрэг дэлхийн томхон агентлагууд үе үе мэдээ, таамаг цухалзуулдаг. Тэдгээрийн заримаас түүвэрлэн авч үзье.

Юуны өмнө дэглэм солигдох хувилбарууд барууны ба өмнөд солонгосын судлаачдын дэвшүүлж таамагласан хэд хэдэн хувилбараас багцалж дор сийрүүлбэл:

- 1) Ким Чен Ир-ийн удирдлага дор дэглэм шилжилт хийх
- 2) Аажмаар хязгаарлагдмал хүрээнд хөршүүддээ нээлттэй болох
- 3) Мьянмар маягаар реформист цэргийнхэн ба технократуд эвсэж засгийн эрхийг авах
- 4) Бүр мөсөн сүйрэх. Энэ нь улс төр, эдийн засаг-нийгэм бүхэлдээ тэсрэх, иргэний дайн, үй олон сая дүрвэгсэд

5) Энэ дэглэмийг цөмийн зэвсгийн хөтөлбөрөөр нь далимдуулан өрсөж цохилт өгөх хувилбарыг ч зарим нэг судлаач үгүйсгэхгүй байна. Тухайлбал 500 объектод цохилт өгөх цэргийн хувилбарыг АНУ-д 1990-ээд дундуур боловсруулж байжээ.⁴⁴

Дээрхээс эхнийх нь огт хийгдэхгүй, хоёр дахь нь хийгдэж болох, Ким Чер Ир үхсэн букуу өөрөө зайлсан тохиолдолд вакуум үүсвэл гурав дахь нь магадлалтай, дөрөв дэх нь олон сая хүний амиар бүтэх, тав дахийг Өмнөд Солонгос зөвшөөрсөн тохиолдолд АНУ хийх гэхчлэн таамаглаж болно.

Дэглэмийг устгахаар шууд дайн хийсэн тохиолдолд ямар үр дүн гарах вэ? Энэ дэглэмийг хүчээр түлхэн унагаах бусад хувилбарыг олон жилийн тэртээ боловсруулсан нь ч хүчинтэй хэвээр үлдэж байна. Цэргийн хүчээ АНУ энэ бүс нутагт зузаатгасаар ирсэн нь дараахи болзошгүй гурван аюулаас үүдэлтэй бөгөөд энэ нь АНУ-ын аюулгүй байдлыг шууд хөндөх гэнэ. Үүнд:

1) Японы аюулгүй байдлыг хэн ч хөндөж болохгүй, хэрэв тэгвэл АНУ-д халдсан лугаа адил үзнэ

2) Хойд Солонгосоос ямар ч балмад авантюр дэгдээж болзошгүй

3) Тайванийн хоолойн хоёр эргийн хооронд, Хятадаас Тайвань руу зэвсэгт халдлага үйлдсэн тохиолдол бол мөн л АНУ-ын ашиг сонирхлыг сүрхий хөндөнө.⁴⁵

Тэртээ 1950 оных шигээ Хойд Солонгосоос Өмнөд рүү гэнэт довтолж болзошгүй гэсэн таамаглал ямагт бодитой байж ирсэн, болзошгүй энэ дайн болон террорист гэнэтийн халдлагын аюулд Өмнөд Солонгос ард иргэдээ бэлэн байлгах сэрэмжлүүлэг байнгынх байх ёстой. Ийм довтолгоон эхлэх өдөр судрыг хэн ч мэдэхгүй. Цаг агаарын байдал, байлдааны бэлтгэл, олон улсын хүчин зүйлээс үл шалтгаалан Хойд Солонгосын 2 сая гаран цэрэг байлдааны өндөржүүлсэн бэлэн байдалд байнга байж ирсэн. Ийм нөхцөлд Өмнөд Солонгос дахь америкийн 37000 цэрэг, Өмнөд Солонгосын хагас сая цэрэг хариу цохилт өгөх бэлтгэлээр ямар билээ. Умардаас дайн гэнэт эхлэх нь эргэлзээгүй гэдгийг тооцоолон Номхон далай дахь флот ба цэргийн хүчнээ бүгдийг дайчлах, Японоос ар талын хангалт тасралтгүй хийлгэх тухайд АНУ аль хэлийнэ хариу тооцоо хийжээ. АНУ нь нэгэн зэрэг дэлхийд гурван өөр фронт дээр ялалт байгуулж чадна гэсэн Батлан хамгаалахын өмнөх сайд Рамсфелдын үг оргүй сүрдүүлэг биш юм.

Хэдийгээр дэлхий дахин АНУ-ын хүч чадалд итгэх ч тэрхүү “чөлөөлөлт” нь ихээхэн эрсдэл дагуулах, тэр нь олон жилийн үр дагавар үлдээх явдал гэж үзэх явдал бас байна. Сталинч Хойд Солонгосын эсрэг дайн нь дараахи гурван хувилбараар явагдаж болзошгүй гэсэн таамаглалыг стратеги судлаачид хийж буй.⁴⁶ Үүнд:

1) “Цахилгаан дайны” хэлбэрээр буюу 4-6 долоо хоног үргэлжлэх магадлалтай. Агаараас асар хүчтэй довтлон бөмбөгдсөний үр дүнд Хойд Солонгосын батлан хамгаалахын дэд бүтэц, гол түшиц газрууд устгагдаж, цэрэг арми нэгдсэн бүтэц, жолоодлогогүй болно. Хүнд цохилтын улмаас сарнин бутарсан Солонгосын ардын арми эсэргүүцэл үзүүлэлгүй бууж өгөх тохиолдолд АНУ, Өмнөд Солонгос хуурай замын цэрэг оруулж, хохирол бараг хүлээхгүйгээр хойдуулын зэвсгийг хурааж, улмаар Пхеньяныг авч, Ким Чен Ирээс (тэрээр нуугдах буюу амиа хорлох, эсвэл Орос, Хятадын аль нэг рүү зугтаж тэндээ бүгнэ) бусад толгойлогчдыг баривчилна. Агаарын хүчтэй довтолгооныг эсэргүүцэх бололцоо хойдууд бараг байхгүй, тооцоолсноор бол Хойд Солонгосын байлдааны нисэх онгоцуудын 70 хувь нь шатахуунгүй, тэгээд ч Миг-19, Миг-21-ээр америкийн агаарын “Армада”-г хүчрэхгүй. Завсрын иргэний засаг захиргаа Пхеньянд байгуулж хэв журам сахиулахад шаардлагатай Өмнөд Солонгосын хүчнийг үлдээн АНУ гол хүчнээ гаргаснаар байлдааны ажиллагаа шувтрах эхний хувилбар байна.

2) Агаараас хүнд цохилт авах хэдий ч Солонгосын ардын арми нь байлдах чадвартай үлдэх бөгөөд АНУ хуурай замын цэргээ оруулж 6-12 долоо хоногийн турш зууралдан, гудамж болгоны төлөө дайтах шаардлага тулгарна. АНУ, түүний холбоотон - Өмнөд Солонгос нь бие бүрэлдэхүүний хувьд хохирол амсах нь гарцаагүй, фанатик хойд солонгосчууд цөмийн байгууламж, цахилгаан станц, усан сангуудаа тэсэлж дэлбэлснээр эдийн засгийг нь эргэж сэргээх тооцоо алдагдах магадлалтай. Энэ тохиолдолд зөвхөн Солонгосын хойгоор үл барам бүс нутгийг хамарсан эдийн засаг-экологи-хүмүүнлэгийн асар их хямрал нүүрлэнэ. Хэдийгээр хүсмээр биш ч, Пхеньяны сталинч дэглэм ийм хувилбарыг хариу барихаас сийхгүй гэнэ.

3) Довтолгоон эхэлсэн анхны мөчөөс Хойд Солонгос нь сөрөг довтолгоон хийж, Өмнөд Солонгосын хил даван орох бөгөөд АНУ-ын цэргийн бааз, авианосец руу пуужин харваж, Өмнөд Солонгосын хилийн дагуухи хот тосгодыг түймэрдэн, Өмнөд Солонгосын эдийн засгийг мөлдөө сэргэхээргүйгээр хорлон сүйтгээд, эргээд өөрөө арчигдах гай гамшгийн хувилбар байхыг үгүйсгэхгүй. Энэ тохиолдолд дайн 6 сараас доошгүй хугацаагаар сунжрах бөгөөд АНУ, түүний холбоотон - Өмнөд Солонгос нь Хойд Солонгосын нутаг руу цэрэг оруулан хохирол ихтэй тулалдаан газар сайгүй явагдаж, хил дагуу дүрвэгсдийн тоо хэдэн саяар өсч, хөрш Орос, Хятад, Хятадаар дамжин Монгол, мөн далайгаар дамжин Япон гэхчлэн санаанд багтамгүй үйл явдал өрнөх магадлалтай.

Хойд Солонгосын эрэг довтолгоон тус орны эдийн засагт ямар хохирол сүйрэл учруулах, түүнийг нь сэргээн босгоход хэдий хэмжээний тусламж хэрэгтэй, ялангуяа довтолгоон эхэлмэгц дайны хөлд үй олноор нэрвэгдэх энгийн номхон иргэдэд шаардлагатай хүмүүнлэгийн тусламжийг

ямар аргаар шуурхай хүргэх асуудалд Европын Холбооны орнууд одоо түлхүү анхаарч, элдэв хувилбар боловсруулж байгаа.⁴⁷

Энд анхаарахгүй өнгөрч болохгүй бас нэг асуудал бий. Хэрэв хэрэг явдал буруу тийшээ хэлбийвэл өмнөх түүх давтагдсан савалгаа болох. Тодорхой хэлбэл дэглэмийнх нь увайгүй, явцгүйг мэдсэн хэрнээ дайн дэгдсэн тохиолдолд хөрш ОХУ, БНХАУ-ын бодлого, байр суурь савлаж өрнөдийнхний эсрэг эргэх магадлал маш өндөр байж болох юм.

Тэр нь 1950-иад оны Солонгосын дайныг санагдуулам хэмжээнд арай очихгүй, гэвч тэр хоёр эвсэж Хойд Солонгосыг зэвсэглэвэл тааж хэлэмгүй үр дагавартай. Бяцхан түүх сөхвөл СССР нь 1946-1950 онд Солонгосын ардын армийг байгуулж өгсөн ба 200 генерал, ахлах офицероо командлалд нь ажиллуулсан, суман батальон нь хүртэл орос сургагчтай байсан. 1950-1953 оны дайны бүх дэд бүлгийг оросууд хянаж, 360 дивизийн захирагчаар нь оросууд ажиллаж, тийрэлтэт нисэх хүчнийг Өмнөдийнх нь эсрэг оросууд жолоодон байлдаж, Эх орны дайны домогт нисгэгч Кожедуб нисэх дивизийн захирагч байж, СССР-ийн БХЯ-ны сайд маршал Булганин, Жанжин штабын дарга армийн генерал Штеменко нар коммунист нам, Зөвлөлт төрийн өмнө Солонгосын дайныг шууд хариуцаж гэхчлэн түүхэн тоо баримтыг эдүгээ хүртэл Пхеньянд дурсан санасаар буй.⁴⁸

Дайн дуусаад энхийн бүтээн байгуулалт ид явж байтал 1964 онд оросууд сөнөөгч авиачын курпус, зенитийн пуужингийн хоёр дивиз байгуулж өгсөн ба 1965 онд СССР-ийн тусалцаатайгаар Ёнбэнд цөмийн судалгааны төв байгуулж улмаар IRT-2M гэдэг реактор ашиглалтад оруулан, 1970-аад онд цөмийн түлш гаргаж авч, 1974 онд IRT-2M реакторын хүчин чадлыг нь 8 мегаватт болгон шинэчилсэн⁴⁹ гээд Хойд Солонгосын ирээдүйн дайнд Орос улс савлах баримтууд бэлхнээ байна.

Тав. Дэглэмийг яах вэ?

Тус оронд яг одоо цэвэрлэгээ явагдаж, төрийн террор үргэлжилж байгаа гэх баримтууд төдийлөн байхгүй байна. Харин цэрэг-дайны бэлтгэлийг нэг ч өдөр алгасахгүй хийж, ямар ч үнээр боловч сталинч дэглэмээ авч үлдэхийг зорих нь гарцаагүй. Зарим судалгаагаар Хойд Солонгосын нийгэм дэх “Дайсагнагч хүчин” нь 3 сая, “Төвийг сахигчид” нь 15 сая, “Найрсаг хүчин” нь 2 сая хүн байгаа⁵⁰ баримтаар бол гаднаас цохилт өгөхөд энэ нийгэм дотроосоо дэлбэ үсрэх байдал ч ажиглагдаж магадгүй бололтой.

Нийгмийн байгуулал, улс төрийн дэглэмийн буруу сонголт, эдийн засгийн буруу тогтолцоо нь тус орныг огт өөдлүүлэхгүй гэдэг нь 1990-ээд оны эхээр тодорхой болсон. 1995 он гэхэд тус орон сүйрлийн ирмэг дээр ирсэн ба хүнсний хямрал нүүрлэж, өлсгөлөн болсныг 1996-1997 онд Пхеньяны дэглэм хүлээн зөвшөөрч, буруутнаар нь үерийг тодруулсан. 1996-

2000 онд болсон их өлсгөлөнгийн үед 250000-2 сая хүн өлбөрч үхсэн гэх баримтыг гадаадын судлаачид, олон улсын ба буяны байгууллагууд хийсэн байдаг. Энэ нь хүн амын 1-10 хүртэл хувь нэрвэгдлээ гэсэн үг. Хойд Солонгосын үйлдвэрүүдийн 70-80 хувь хаалгаа барьчихаад байна. Зөвлөлтийн эдийн засгийн тусламж зогсмогц л 1992-1995 онд тэдгээр үйлдвэрүүд жагсаалаас гарсан. Хүн амынх нь 90 хувь нэн ядуу, ДНБ-ийх нь 95 хувь гадаад өрөнд явдаг гэхчлэн ноцтой баримтууд жагсааж болно. Засаг захиргааны хүнд суртал, кадр ажилтнуудын хээл хахуулийн хэрэг дэглэмийг улам бүр сулруулж, 1995-2002 онд төрийн удирдлага хямралд орлоо. Энэ байдлаас үүдэн эдийн засгаа аажмаар нээх, жижиг бизнесийг дэмжих бодлого руу 2002 оноос шилжиж байна.

Энэ бодлого хэр оновчтой үргэлжлэх, ард түмнийх нь аж амьдрал сайжрах эсэх, өмнөд хөрштэйгээ халз уралдвал сөхрөх, хоёр Солонгосын эргэж нэгдэх ирээдүй цагийн үйл явц гээд урьдчилан таашгүй үйл явдлууд дэлхий нийтийн гайхшралыг нэг хэсэгтээ барсаар байх болов уу.

Харин гадаад бодлогодоо сонгож авсан тактик нь хэр удаан үргэлжлэх эсэхийг хэн ч мэдэхгүй. Эдийн засаг нь гүн хямралд нэрвэгдэж, өлсгөлөнгөөр 2 сая хүнээ алдсан ба цэрэгжсэн дэглэмээ торгоох шинэ тактик Ким Чен Ир сонгоод байгаа ба тэр нь айлган сүрдүүлэх, заналхийлэх замаар олон улсын тусламж байнга хүртэж байх явдал болоод байна. Эдүгээ өөрсдийнх нь үзэж чаддаггүй АНУ тус улсын эдийн засгийн хамгийн том хандивлагч болчихоод байгаа нь тэрхүү шинэ тактикийнх нь ид шид гэлтэй.

Солонгосын хойгийн эдрээтэй асуудлаас улбаалан бүс нутгийн аюулгүй байдлын асуудал нааштай шийдэгдэх төлөв ажиглагдахгүй байна. Бүс нутгийн аюулгүй байдлын асуудалд Пхеньяны дэглэм туйлын ойлгомжгүй, барьшгүй байр суурь баримталж байна.

Хойд Солонгосын дэглэм нурсны дараахи тус улсын нийгэм-улс төр, эдийн засаг, хүн амын байдлыг яг бодитойгоор төсөөлж таамаглаж байгаа судлаач, ирээдүйч нар одоо хаана ч алга байна гэхэд болно. Эл асуудлыг өмнөд солонгос, япон, америк, оросын эрдэмтэд таамаглахыг зорьж байгаа ч тэсрэн гарах аюул, эрсдэлийг хэн ч таамаглахыг хүсэхгүй байна.

ЭШЛЭЛ, ЗҮҮЛТ

1. Северная Корея всенародно отмечает день рождения Ким Чен Ира - РИА Новости, 16.02.2005
2. <http://www.lenta.ru/lib/14164295/> Ким Чен Ир: Лидер КНДР
3. А.Н.Ланьков. Неформальная история Северной Кореи, Москва, 2005, 63 дахь талд
4. Laura McClure. Understanding Kim Jong Il.- Salon.com, 10.01.2003
5. А.Н.Ланьков. Борьба фракций в КНДР, "Восток", 1992 №5
6. Suh Dae-suk. Kim Il Sung: The North Korean Leader. New York, Columbia University Press, 1988

7. А.Н.Ланьков. Неформальная история Северной Кореи, Москва, 2005, 62 дахь талд
8. Мөн тэр номд, 65 дахь талд
9. Ким Ир Сен. Мемуары: В водовороте века (I), Корея, Пхеньян, 1992, 6 дахь талд
10. Мөн тэр номд, 58-59 дэх тал
11. Profile: Kim Jong-il. - BBC News, 09.10.2006
12. Kim Jong Il: Playing a poor hand skillfully. - CNN, 21.08.2003
13. <http://www.lenta.ru/lib/14164295/> Ким Чен Ир: Лидер КНДР
14. Laura McClure. Understanding Kim Jong Il. - Salon.com, 10.01.2003
15. Северная Корея всенародно отмечает день рождения Ким Чен Ира - РИА Новости, 16.02.2005 Kim Jong Il: Playing a poor hand skillfully. - CNN, 21.08.2003
16. Profile: Kim Jong-il. - BBC News, 09.10.2006
17. <http://www.lenta.ru/articles/2006/02/16/diktator/> Операция “Преемник” по-северокорейски
18. Мөн тэнд
19. North Korea’s repatriation of overseas children, Vantage Point, June 2007- Vol. 30 No 6, page 25
20. Мэдээллийн журмаар сонирхуулахад: БНАСАУ нь дэлхийн 156 улстай дипломат харилцаатай, үүнд Азийн 25, Америкийн 22, Европын 49, Ойрхи Дорнодын 16, Африкийн 44 улс, эдгээрээс гадаадын 43 улсад 50 ДТГ-тай (ЭСЯ ба ЕКГ, Консулын газар), Азид 14, Америк тивд 4, Европт 12, Ойрхи Дорнодод 5, Африкт 8 ДТГ ажиллаж байна.
21. Kim Jong Il Profile. - NNDB.com
22. Өмнөд Солонгосын “Син Дона” сэтгүүлд хойд солонгосын дипломатч асан Ким Ен Хваны ярьсныг ИНО ТАСС “Компас” товхимолын 1992.01.28-ны №17-т хэвлэснээс эшлэв.
23. Robert Scalapino & Chong-sik Lee. Communism in Korea, Berkley, The University of California Press, 1972 Dae-sook Suh. The Korean Communist Movement: 1918-1948, Princeton, Princeton University Press, 1967
24. А.Н.Ланьков. Неформальная история Северной Кореи, Москва, 2005, 111-112 дахь талд
25. Пукхан инмён сажон (Хойд Солонгосын намтрын толь бичиг), Сөүл, Чунъяань ильбо са, 1990 Ян Ханмо. Намнодань-ый моллак-гва Пак Хон Ён-ый чвеху (Өмнөд Солонгосын Хөдөлмөрийн намын мөхөл ба Пак Хон Ёны төгсгөл) “Пукхан” сэтгүүл, 1985 №8
26. Чухам энэ үеэс түүнийг “Жолоодогч” гэх болж, “Сурён” гэх үг солонгос хэлнээ нэвтэрчээ.
27. Suh Dae-suk. Kim Il Sung: The North Korean Leader. New York, Columbia University Press, 1988
28. Мөн тэр номд

29. Интервью с Пак З.П. 1 февраля 1991г, Ташкент
30. Пукхан инмён сажон (Хойд Солонгосын намтрын толь бичиг), Сөүл, Чунъяань ильбо са, 1990
31. А.Н.Ланьков. Неформальная история Северной Кореи, Москва, 2005, 224 дэх талд
32. Мөн тэр номд, 225 дахь талд
33. Мөн тэр номд, 227 дахь талд
34. Мөн тэр номоос эшлэв. Нийт хүн амыг хамарсан цэвэрлэгээ, шалгалт, хяналтын сүлжээний сонгогдог загварыг энд жишээллээ. Загвар нь загвар л юм. Гэхдээ арай хэтрүүлсэн байна. Хойд солонгосчуудын ажилсаг хөдөлмөрч, сахилга, зохион байгуулалттайг бид гайхдаг бол тэдний сайн талыг ийм 51 ангилал нь хөгжүүлж өгчээ.
35. Игорь Крючков, Василий Гулин, Ольга Горбунова. Нежданный член.- gzt.ru, 10.10.2006. №184
36. КНДР пригрозила ООН “страшной войной”, <http://www.lenta.ru/world/2004/07/27/korea/>
37. Монгол Улсын Гадаад харилцааны яам, Илтгэх хуудас, 1999.09.21, Пхеньян хот
38. Пхеньян провел ядерные испытания. gzt.ru, 09.10.2006 КНДР отказалась от переговоров по ядерной проблеме. - РБК, 27.09.2006
39. Kim Jong Il Profile.- NNDB.com
40. Кимченирия: Куда ведет страну любимый вождь? <http://vip.lenta.ru/news/2003/04/28/korea/>
41. Мөн тэнд
42. Мөн тэнд
43. Мөн тэнд
44. Innovative Approaches to Peace and Stability in Northeast Asia: Focus on the Korean Peninsula, International Conference. Moscow 26-28 May, 2005
45. Ted Osius. The U.S.-Japan Security Alliance (The Washington Papers/ 181), CSIS, 2002
46. Контрольный выстрел Ким Чен Ира, <http://vip.lenta.ru/news/2004/09/23/korea/> Кимченирия: Куда ведет страну любимый вождь? <http://vip.lenta.ru/news/2003/04/28/korea/>
47. Георгий Булычев. Ким Чен Ир жаждет нормализации отношений с Западом. Время новостей, 25.02.2005 №32
48. А был ли поезд? Куда и зачем поехал Ким Чен Ир. РИА Новости, 23.06.2006 Innovative Approaches to Peace and Stability in Northeast Asia: Focus on the Korean Peninsula, International Conference. Moscow 26-28 May, 2005
49. Пхеньян провел ядерные испытания. gzt.ru, 09.10.2006
50. Orwell's Nightmare: Human Rights in North Korea, The Heritage Lectures, No 394, Washington, Heritage Foundation, 1992